



ISSUE #18

20 January 2012

## ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн байцгаана уу,

2012 оныг бид амжилттай эхэлж байна.

Mrs. Hanselmann, Mr. Elya нар Бангкок, Хонгконг-д болсон багш сонгон шалгаруулах арга хэмжээнд оролцож ОУДС-д багшлах хэд хэдэн багш нарыг ажилд сонгож авсан. Би бас эдгээр багш нарыг ажилд авсанд сэтгэл хангалуун байгаа бөгөөд манай сурагчид болон эцэг эхчүүд та бүхэн 8 сард шинэ багш нартай уулзаад баяртай байх болно гэдэгт би итгэлтэй байна.

Дэд Захирал Туул бид хоёр ирэх Лхагва гарагт Канад, Америк руу багш шалгаруулж ажилд авахаар явах гэж байна. Бид хоёрдугаар сарын дундуур ирэх бөгөөд чадварлаг, авъяастай багш нарыг сонгон шалгаруулж авах болно гэдэгтээ итгэлтэй байна.

Хичээлийн жилийн төгсгөлд бид шинээр ажилд авсан багш нарыг та бүхэнд товч танилцуулах болно. Хичээлийн жилийн төгсгөлийн энэ үеэр бид шинэ багш нартай танилцдаг боловч буцаж байгаа багш нартаа баяртай гэж хэлэх амаргүй байдаг. Одоо энэ талаар ярихад арай эрт байнаа.

Би ирэх хэдэн долоо хоногт томилолтоор гадаадад ажиллах тул хэсэг хугацаанд Мэдээ бичихгүй байх болно. Энэ долоо хоногийн Мэдээнд би хичээлээс гадуур зохиогддог дугуйлангийн хөтөлбөрийн талаар товч мэдээлэлийг та бүхэнд хүргэж байна. Дугуйлангууд хичээллэж эхлээд 2 улирал аль хэдийн өнгөрчээ. Удахгүй 3-р улирлын дугуйлангууд эхэлнэ.



Манай дугуйлангийн гол зорилго юу байдаг вэ? Энэ дугуйлангуудыг хичээллүүлснээр бид сурагчдынхаа хамт ямар амжилтанд хүрэх гэж байна вэ?

Зарим сургуулиудын хувьд дугуйлангууд бол танхимын хичээлийн албан ёсны үргэлжлэл байдаг. Өөрөөр хэлбэл сурагчид мэргэжлийн өндөр үр чадвартай багш нараар заалган тухайн

хичээлийг гүнзгийрүүлэн судалдаг гэсэн үг.

Харин манай сургуулийн хувьд дугуйлангууд өөр зорилготой байдаг. Бидний арга барил бол ОУДС-ийн бодлого зорилготой нийцэж байдаг:

Манай дугуйлангийн хөтөлбөрийн гарын авлагат бичсэнээр дугуйланд хамрагдсанаар сурагчид оюуны хувьд хөгжөөд зогсохгүй нийтэч зан чанарыг бас төлөвшүүлэх боломжтой. *Сурагчид өөрсдөдөө итгэлтэй, нээлттэй байж шинэ үр чадварт суралцаж бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэн нэг баг хамт олон болж суралцах боломжтой.*

# THE MEDEE

The Weekly Newsletter of the International School of Ulaanbaatar

FRONT PAGE— THE MEDEE IS AVAILABLE ONLINE EACH WEEK AT: [WWW.ISUMONGOLIA.EDU.MN](http://WWW.ISUMONGOLIA.EDU.MN)

Та бүхэн энэ хэсгээс манай сургуулийн баримталдаг сурагчдын зан байдлын төлөвшилтийн талаарх үгнүүдийг амархан таних боломжтой. Энэхүү зан чанарын төлөвшилтөнд тодорхойлсон зан чанаруудыг сурагчид өөрсдөө хөгжүүлэхэд манай дугуйлангийн хөтөлбөр өргөн боломжуудыг олгодог.

Бид сурагчдаа олон төрлийн дугуйланд хамруулж шинээр сэтгэж, шинэ зүйлд суралцан ирээдүйн мэргэжлээ сонгоход нь тэдэнд урам зориг, шинэ санаа өгөх өргөн боломжоор хангахыг эрмэлздэг.

Жишээ нь урлаг, уран сайхан, гар урлалын дугуйлангуудаар сурагчид өөрсдийн гараар хийж бүтээх, зурж дүрслэх бүтээлч сэтгэлгээнд суралцдаг. Хөгжим тоглож эсвэл жүжигт тоглосоны дараа үзэгчдийн алга ташилтыг хүлээн авах тэр баяр хөөр, уран зураг зурж эсвэл баримал хийж өөрийн дотоод ертөнцөө бүтээлээрээ илэрхийлэх сэтгэл ханамжийг дугуйланд сурсанаар л мэдрэх боломжтой. Нэгэнт сургуулиа төгсөөд ажил эрхлээд ирэхээр манай ихэнх сурагчдад ийм боломж, цаг зав хэр байх бол?

Манай спортын дугуйлангуудын гол зорилго бол эрүүл бие бялдрыг хөгжүүлж спортын төрлөөр хичээллэснээр багийн амжилтын төлөө тоглох, мөн сайн тамирчны зан чанарыг сурагчдад төлөвшүүлэхэд оршдог. Тэд ялалтын баяр хөөр болон ялагдлын сэтгэл дундуур байдлыг хэрхэн хүлээж авах тал дээр суралцах боломжтой. Бид бас багийн спортоос гадна ганцаарчилсан спортын дугуйлангуудыг хичээллүүлдэг. Сайн бэлтгэл, мэрийлт, хичээл зүтгэл, чиглэсэн зорилгодоо хүрэх тал дээр өөрийгөө хөгжүүлж амжилт гаргахад нь бид сурагчиддаа дэмжлэг үзүүлдэг.



Бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэн олон жижиг шүрээр гоёлын зүүлт хэлхэх, шаар үлээж төрөл бүрийн тоглоом хийх, тэвчээртэйгээр хатгамал хатгах, ном уншиж уншсан номоо ярилцах гэх мэт ямар ч төрлийн дугуйлан байлаа гэсэн манай бүх дугуйлангууд сурагчдад тэр болгон үүлзаад байдаггүй найз нартайгаа хамтран нэг ангид энгийн чөлөөтэй байдалд цагийг бүтээлчээр өнгөрүүлэх боломжуудыг олгодог юм. Том жижиг, монгол гадаад, эрэгтэй эмэгтэй сурагчид бүгд адилхан нэгэн дор өөрсдийн дуртай дугуйландаа суралцах энэ боломжоор хангагдсан байдаг.

Багш сурагчид ч гэсэн хамтран дугуйлан хичээллүүлэхдээ бие биенийгээ сайн дотно таньж хамтран ажиллах боломжтой. Багш нар дугуйлан хичээллүүлж байгаа сурагчдынхаа зарим авъяас чадварыг шинээр нээн илрүүлж үүнийгээ танхимынхаа сургалтанд бас ашиглах боломжтой. Сурагчид ч бас танхимаас гадуурх орчин нөхцөлд багш нарыгаа илүү таньж мэддэг боломжтой.



Танхимаас гадуурх байгаль орчинд хийгддэг сургалтын бусад арга хэмжээний үеэр, нийгмийн тустай хөдөлмөрийн бүтээлч ажил хийж байхдаа манай сурагчид өөрсдийн бэрхшээлийг хэрхэн даван туулах талаар суралцаж тэдний хувь нэмэр, оролцоо бусдад хичнээн үнэ цэнэтэй байдгийг олж мэддэг юм. Танхимын хичээлээс гадуур олж судлах хичнээн их зүйл байдгийг сурагчид мэдэж авдаг.

Манай удирдлагын багийн хамт олон өнгөрсөн улиралд дугуйлангийн хөтөлбөрийн талаар ярилцаж сургуулийн зорилго, эрхэмлэх зүйлс, хэтийн зорилготой энэ бүхнийг хэрхэн уялдуулах тухай дэлгэрэнгүй ярилцсан.

Бид ...

- ИВ хөтөлбөрийн гол цөм болсон сэтгэн бодох, үйл ажиллагаа, нийгмийн туст үйлчлэлийн зарчимтай манай хөтөлбөрүүд уялдаж байгаа эсэх
- Эцэг эхчүүдээр дугуйлан удирдуулах буюу тэднийг дугуйлангийн үйл ажилд хэрхэн оролцуулах;
- Сурагчдынхаа эрэлт хэрэгцээг бид хангаж байгаа эсэх;
- Багш нар маань өөртөө итгэлтэй байж, аливаад нээлттэй хандаж сурагчиддаа үлгэр дууриал болохын тулд тэднийг шинэ туршлага хуримтлуулж шинээр сурч мэдэх боломжоор бид хангаж байгаа эсэх;
- Хичээлийн жилийн туршид дугуйлангаа ямар журмаар хичээллүүлэх-улирал улирлаар, хоёр семестрээр, эсвэл жилийн туршид нэг дугуйланг тасралтгүй хичээллүүлэх гэх мэт;
- Бүх дугуйлангууд ОУДС-ийн эрхэмлэх зүйлс, зорилго хэтийн зорилготой заавал үялдсан байх эсэх гэх мэт олон асуудлаар бид дэлгэрэнгүй ярилцсан.



Бид энэхүү хэлэлцүүлгийг дөнгөж эхлүүлээд байна. ОУДС-д хамгийн сайн тохирсон хөтөлбөрийг боловсруулахын тулд бид энэ асуудлаар бас та бүхний санал хүсэлтийг авах болно. 3-р улирлын дугуйлангийн талаарх мэдээлэлийг удахгүй та бүхэнд явуулна. Шинэ зүйл суралцах, бусдад туслах хүсэлд тань тохирсон дугуйланг сонгоход бэлэн байгаарай.

**Захирал Robert Stearns**

## **ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:**

1 сарын 23-25	11-р ангийн 1-р семестрийн Дипломын шалгалт
1 сарын 27	1-р семестрийн хичээл дуусна
1 сарын 30	2-р семестрийн хичээл эхэлнэ
1 сарын 31	3-р улирлын дугуйлангууд эхэлнэ

## **ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

Өнгөрсөн долоо хоног миний хувьд 2012 оныг эхлүүлсэн анхны долоо хоног байлаа. Сурагчид маань шалгалт шүүлгээ өгч бие даалтын тайлангаа хамгаалахад бэлтгэж хичээлдээ шамдан суралцаж байна. Төгсөх ангийн сурагчид маань 5 сард болох Дипломын хөтөлбөрийн урьдчилсан шалгалтуудаа өгч байна.

11-р ангийн сурагчид маань семестрийн төгсгөлийн шалгалт шүүлгүүдээ өгч, 10-р ангийн сурагчид бие даалтын тайлангаа хамгаалахад бэлтгээд завгүй байна. Энэ бүх сургалтын ажлууд хичээлийн жилийн туршид явагддаг бөгөөд хүн бүр л нэг семестр дуусгах гээд завгүй ажиллаж байна. Та бүхэн энэ хариуцлагатай үед нь хүүхдүүддээ тусалж тэднийг сайн хооллож, сайн унтуулж амрааж шингэний дутагдалд оруулахгүйн тулд усаа сайн уухад нь анхаарал тавиарай.

<http://www.aws.com/wx.asp?id=ULNBT&units=1> энэ хаягаар орж Манай сургуулийн дээвэр дээр байдаг цаг уурын станцаас та бүхэн цаг агаарын мэдээлэл авах боломжтой. Сүүлийн үед хүйтний эрч эрс чангарч байгаа тул бид бүх сурагчдаа цаг агаарын байдалд тохируулан дулаан хувцаслаж байхыг хүсэж байна.

ОУДС-д шинээр хэд хэдэн гэр бүлүүд нэмэгдэж ирсэн бөгөөд манай хуучин эцэг эхчүүд шинэ гэр бүлүүдийг манай хамт олны нэг хэсэг болоход нь туслан найрсгаар хүлээж авч байдаг бид үргэлж баяртай байдаг. Жижиг сургуулийн хувьд энэ нь хамгийн чухал эерэг зүйлийн нэг байдаг бөгөөд бид хамт олноороо хүн бүрийг баяртайгаар хүлээж авдаг. Та бүхэн сард нэг удаа болдог манай эцэг эх багш нарын бүлгийн хуралд ирж оролцоорой.

Бид Монголоос буцаж байгаа зарим нэг гэр бүлийхэндээ баяртай гэж хэлээд тэдэнд цаашдын ажил, хичээл сурлаганд нь амжилт хүсье.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

**Их Дээд Сургуулийн элсэлтэнд бэлтгэх  
ЗӨВЛӨЛГӨӨ ӨГӨХ УУЛЗАЛТ  
1 сарын 25-ны Лхагва гарагт 18:00  
ОУДС-ийн Номын Санд болно**

**10, 11-р ангийн бүх сурагчдыг эцэг эхчүүдийн  
хамт оролцохыг урьж байна**

**Та бүхэн энэ уулзалтын үеэр их дээд сургуулийн элсэлтийн талаар мэдээлэл авч Хонг Конгоос ирсэн манай зочин Bob Mansueto-той уулзаж ярилцаарай.**

**Дэлгэрэнгүй мэдээллийг Ms Richard-аас авна уу.**

## БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Өвлийн амралт, багш нар сонгон шалгаруулах арга хэмжээг дуусгаад сургуульдаа буцаж ирэх сайхан байна. Сурч мэдэхийн төлөө шамдаж байгаа сурагчдаа, тэдний эрч хүчийг харахад үргэлж урамтай сайхан байдаг.

2-р семестр эхлэхэд манай бага сургуульд зарим нэгэн шинэ багш нар ажилд орно. 2-р ангийн багш Mrs. Reed Канад руу нутаг буцах болсон. Тэрээр 1 сарын 27-ны Баасан гарагт ажлаа дуусгаж хүлээлгэж өгнө. Mrs. Reed-ийн манай сурагчдын төлөө хийсэн бүх зүйлд нь би талархал илэрхийлж байна. 1 сарын 30-ны Даваа гарагаас эхлэн Mr. Jonathan Nock 2-р ангийн багшаар ажиллана.

1 сарын 27-нд 1-р ангийн түслах багш Mrs. Tsatsral жирэмсний амралтаа авна. Эдний гэр бүлд нэмэгдэх шинэ хүнтэй бид удахгүй уулзах болно.

Хичээлийн дараа сургуулийн ресепшиний утсаар ярих гэсэн сурагчдын тоо ихэслээ. Та бүхэн хичээлийн дараа сурагчдыг авах унааны зохицуулалтыг өглөө хичээлд ирэхээс нь өмнө хийж байгаарай. Ресепшиний утас сурагчдын хэрэгцээнд зориулагдаагүй болохыг анхаарна уу. Та бүхэн амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй!

Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya



2012 онд ОУДС-ийн 20 жилийн ойг манай хамт олон тэмдэглэн өнгөрүүлэх гэж байна.

Эрхэм хүндэт эцэг эхчүүд, багш сурагчид, манай сургуулийг төгсөгчид та бүхнийг боловсролын салбарт 20 жилийн туршид бидний оруулсан хувь нэмэр, хийж бүтээсэн ололт амжилтыг бидэнтэй хамтран тэмдэглэн өнгөрүүлэхийг урьж байна.

Хэрэв та бүхэн 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх Комиссын бүрэлдэхүүнд орж ажиллахыг хүсвэл [admissions@isumongolia.edu.mn](mailto:admissions@isumongolia.edu.mn) хаягаар Ms. Эрдэнэбилэгтэй холбоо барина уу.

# ЦАГААН САРЫН АМРАЛТЫН ТАЛААРХ ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ

Эрхэм Хүндэт Эцэг Эхчүүдээ,

Цагаан Сарын баярын өдрүүдийн талаар бид эцсийн шийдийг хүлээж байгаа боловч одоо болтол яг албан ёсны мэдээлэл бидэнд байхгүй байна.

Намрын улирлын сүүлчээр бид Цагаан Сарын өдрүүд 2 сарын 22,23-ны Лхагва, Пүрэв гарагуудад таарах тухай зарим мэдээлэл авч байсан. Одоог хүртэл энэ мэдээлэл хамгийн найдвартай мэдээлэл болж байна.

Мөн түүнчлэн олон сургууль, албан газрууд 2 сарын 24-ний Баасан гарагт амрах талаар мэдээлэл аваад байна.

2 сарын 24-ний Баасан гарагт амралтын өдөр үргэлжлэх буюу шилжих магадлал байгааг харгалзан бид энэ өдөр хичээл орохгүй гэсэн шийдвэр гаргалаа.

Иймээс манай сургууль Цагаан Сарын Баяраар **2 сарын 22-23-24** (Лхагва, Пүрэв, Баасан)-ний өдрүүдэд амарна.

Жилд хичээллэх ёстой хоногийн тоонд энэ өөрчлөлт нөлөөлөхгүй.

Бид яагаад хожуу энэ шийдвэрт хүрэх болсоныг та бүхэн ойлгоно гэдэгт итгэлтэй байна.

**Захирал Robert Stearns**

2012 оноос эхлэн бид та бүхэнд УБ хотноо болж байгаа зарим нэг арга хэмжээнүүдийн талаарх зарыг хүргэхээр боллоо.

## Монгол Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театр

2012 ОНЫ 1-Р САРЫН ТОГЛОЛТ

21.01.2012 17.00 цаг	Ц.Нацагдорж ҮҮЛЭН ЗАЯА дуурь
22.01.2012 17.00 цаг	П.И.Чайковский "НОЙРССОН ГҮНЖ" балет
27.01.2012 19.00 цаг	Хийлч О.Байгалийн "Сонгодог эгшиглэн" тоглолт
28.01.2012 17.00 цаг	Дж.Верди ТРУБАДУР дуурь
29.01.2012 17.00 цаг	Ж.Чулуун УРАН ХАС балет
30.01.2012 19.00 цаг	Балетмейстер Н.Чинзоригийн уран бүтээлийн үдэш

**Хаяг:** Монгол Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театр  
Отгонжаргал Менежер-99024933  
Алтанцэцэг ДБЭТ-н касс 70110389

Дэлгэрэнгүй мэдээлэл <http://www.opera-ballet.mn/>

**Э. Сэлэнгэмөрөн**  
Нийгмийн үйлчлэлийн ажилтан